

Жамбын ДАШДОНДОГ



# ТЭМЭЭНИЙ ЗУРАГ

Ж.Дашдондог

## **ТЭМЭЭНИЙ ЗУРАГ**

Сургуулийн бага, дунд насныханд

Зураач О.Нацагдорж  
Хянан тохиолдуулагч О.Мөнхтуяа  
Хэвлэлийн эх бэлтгэсэн Д.Хишигдалгэр  
Хянагч Ж.Гэрэлмаа



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

Жамбын ДАШДОНДОГ



# ТЭМЭЭНИЙ ЗУРАГ

Хамгийн анх намайг юу зурсан гэнэ? Тэмээ. Ямар ч л гэсэн тэр том амьтныг цаасандаа багтаагаад зурчихсан шүү!



Мундаг байгаа биз? Гайхуулмаар санагдаад болдоггүй. Юу ч гэсэн эхлээд ахдаа үзүүлье.







Ахдаа үзүүлтэл  
магтах нь байтугай  
бүр толгой сэгсэрч  
“Арай л биш байна.  
Мэддэг хүнд үзүүл!

Уран бүтээлд  
зөвлөгөө чухал юм  
гэдэг шүү!” гэв.

Би ч яахав “За!” гээд л  
айлынхаа хаалгыг татлаа.









Хөршийн малчин  
ах зургийг минь зэрвэс  
харснаа "Тэмээ нь ч  
тэмээ. Гэхдээ бөх нь  
арай босоодож!" гэв.

Нээрээ ч юм уу? Би баллаад л, бөх  
нь багасаад л.





Хараад байхнаа нэг л биш.  
Зөвлөгөө авахаар зэргэлдээ айлдаа  
орлоо.



Айлын эмээ шилээ зүүж харснаа  
“Тэмээ нь ч тэмээ. Харин хүзүү нь хэт  
өндөрдөж!” гэв.



Би баллаад л, засаад л. Хүзүү  
нь доошлоод л намсаад л.



Бас л биш дээ. Яая  
даа, байз! Зөвлөх хэн  
нэгнийг хайж саахалт айл  
руу гүйлээ.





Саахалтын өвөө  
сахлаа илэн мушилзсанаа  
“Тэмээ нь ч тэмээ.  
Харахгүй байна уу? Хөл  
нь дэндүү уртдаж!” гэв.



Баллаад л байлаа.  
Засаад л байлаа. Хөл  
нь улам богиносоод л  
байлаа.

Хичнээн ч зөвлөгөө авав?  
Хичнээн ч дахин засав? Эцэст нь  
эргэж ахдаа үзүүллээ.






Ах түүнийг харснаа нүдээ томруулан дуу алдаж “Гээ, тэмээ чинь хувирсаар хулгана болчихлоо гэж үү?” гэв.





Ай, энэ зөвлөгөө гэдэг  
үү? Ямар хүчтэй юм бэ?  
Тэмээг хулгана болгочихдог  
байна шүү дээ та минь!



Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлж буй  
"Хөдөөгийн боловсролыг дэмжих (READ)  
төсөл"-ийн хүрээнд хэлэв.  
Худалдахыг хориглоно.